



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 15 өдөр

Дугаар А/353

Булган сум

Гүйцэтгэгчид гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэхь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын байгууллагуудын их засвар (Улсын хэмжээнд)-Цаг уурын өртөөний хашаа, засвар (Булган, Могод) ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан "Цотан эх" ХХК-тай 39,800,000 (гучин есөн сая найман зуун мянга) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга (С.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

2. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг "Цотан эх" ХХК-ийн захирал (М.Соёлмаа)-д даалгасугай.


3. Тус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэж хөрөнгө ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд хяналт тавихыг Ус цаг уур орчны шинжилгээний төвийн дарга (С.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.

4. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Аймгийн Засаг даргын 2024 оны
05 дугаар сарын 15 нын өдрийн А/ЗСЗ дугаар
захирамжийн хавсралт



| д/д | Нөхцөл шаардлага | Мөнгөн дүн | Хариуцах албан тушаалтан |
|-----|------------------|--|-----------------------------|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Алданги | Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна | Д.Батцогт |
| 2 | Чанарын баталгаа | Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана. | Д.Батцогт С.Жаргалсайхан |